



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, тус газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын албан хаагчдын саналыг үндэслэн Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд хорооны дарга: Б.Одбаяр Систем нэгтгэл, сургалт хөгжлийн газрын дарга.

Дэд хорооны гишүүд: Ц.Бямбажав Завхан аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга;

Т.Гантогтох Сургалт хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн;

Н.Ганчимэг Нийслэл хариуцсан хэлтсийн Үйлчилгээний ажилтан;


Дэд хорооны нарийн бичгийн дарга: Н.Алтансувд Захиргаа удирдлагын газрын Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлан төлөвлөгөө хариуцсан Ахлах мэргэжилтэн.

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гарган эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Б.Одбаяр)-нд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/74 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Д.Жавхлан)-т даалгасугай.

ДАРГА



П.БАТБААТАР

152401000029